



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

Огноо: 2010/06/17/

Дугаар: 216

Улаанбаатар хот

Стратеги төлөвлөгөө батлах тухай /Эрүүл мэндийн боловсролын талаар БСШУЯ-хамтарсан тушаал/

Стратеги төлөвлөгөө батлах тухай

Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28,1,2 дугаар заалтыг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оныүйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхарга хэмжээний төлөвлөгөөний 1.1.7.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн боловсролын талаар 2010-2015 онд баримтлах стратегийг нэгдүгээр, стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.
2. Үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн дэмжлэг туслалцаа авах, хандивлагчдын зээл тусламжийн тодорхой хэсгийг чиглүүлэх болон шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгаж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар (С.Наранцогт), Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Н.Түмэндэмбэрэл) нарт тус тус зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Б.Мишигжав), Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Н.Хүрэлбаатар) нарт тус тус даалгасугай.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Ё.ОТГОНБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

С.ЛАМБАА

Эрүүл мэндийн боловсролын талаар 2010-2015 онд баримтлах стратеги

Нэг. Үндэслэл

Египетийн Каир хотноо анх хуралдсан “Хүн ам ба хөгжил” олон улсын бага хурлаар дэлхийн улс орнууд хүн ам ба хөгжлийн үндсэн зарчим, холбогдох асуудлаар зөвшилцөлд хүрч, 20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө баталсан билээ. Энэхүү бага хурлынилтгэлд “Ирээдүйн хүний нөөцийн төлөөлөл болох хүүхэд залуус, өсвөр үеийнхний эрүүл мэнд, сайн сайхан байдал, чадавхийг дээд зэргээр дэмжихийн тулд эцэг, эх болон нийгмийн зүгээс хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь туйлын чухал” гэж онцлон тэмдэглэсэн юм.

Түүнчлэн “*Эрүүл хүүхэд илүү сайн суралцдаг*” гэсэн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргасан уриа нь хүүхэд эрүүл мэндээ хамгаалах, эрүүл аж төрөх ухаанд багаасаа суралцахад нь дэмжлэг үзүүлж, тэдэнд сургууль, багш нараас эрүүл мэндийн чанартай боловсрол эзэмшүүлэх асуудалд онцгойлон анхаарахын зэрэгцээ эцэг, эх нь гэр орондоо хүүхдээ эрүүл аж төрөх, тэдний хөгжлийг дэмжих орчин бий болгох, улмаар удирдлагын бүх төвшний шийдвэр гаргагчид хүүхэд бүрийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах, суралцах боломж, нөхцөл бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэйг илэрхийлдэг.

Иймээс хүүхэд, залуучуудад хөгжлийн хэрэгцээнд нь тохирсон эрүүл мэндийн цогц боловсрол эзэмшүүлэх ажилд нийгмийн олон талын төлөөллийг оролцуулах, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулахын тулд боловсролын салбарт баримтлах бодлого, арга хэмжээ нь нэгдсэн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хяналт үнэлгээний тогтолцоотой байх шаардлагатай байна.

Энэхүү шаардлагын дагуу юуны өмнө Боловсролын салбарт эрүүл мэндийн боловсролын чиглэлээр баримтлах стратегийг тодорхойлж, дунд хугацааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх нь чухал юм.

Энэхүү стратегийн төлөвлөгөө нь Мянганы хөгжлийн зорилт, Бүх нийтийн боловсролын зорилтууд, Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаа, агуулга,

стратегии төдийгүй манай улсын боловсролын салбарыг хөгжүүлэх үндсэн баримт бичиг болох Боловсролын тухай багц хууль, “Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”, эрүүл мэнд болон боловсролын салбарт хэрэгжиж буй Үндэсний хөтөлбөрүүдтэй уялдах ёстой.

Амьдрах ухаанд суурилсан эрүүл мэндийн боловсрол эзэмшсэнээр хүүхэд, залуучууд бусдыг хүндэтгэх, тэвчээртэй байх, тэгш эрх, жендэрийн талаар ойлголттой болж, эцэг эх, гэр бүл, багш нар, нийгэмтэйгээ эрүүл дотно харилцаа үүсгэж сурахаас гадна аливаа асуудалд хариуцлагатай хандаж, өөрийн ур чадвар, сонирхлоо хөгжүүлэн эрсдэлгүй эрүүл аж төрөх аргад суралцаж, улмаар хичээл сурлага, ажил хөдөлмөртөө илүү амжилт гаргадаг нь амьдралаас харагдаж байна.

Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хуримтлуулсан олон улсын туршлагаас харахад хүүхэд, өсвөр үеийнхэнд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг баримжаалсан амьдрах ухааны чадварт суурилсан эрүүл мэндийн боловсролыг сургуулиар дамжуулан аль болох эрт эзэмшүүлж, хэвшүүлэх нь хамгийн оновчтой, зардал багатай арга зам гэдгийг хүлээн зөвшөөрч, зөвхөн мэдлэг олгохоос гадна эрүүл зан үйл төлөвшүүлэх, хандлагыг өөрчлөхөд анхаарах болсон байна.

Хоёр. Эрүүл мэндийн боловсролын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

БСШУЯ-наас холбогдох яамд, төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтран ерөнхий боловсролын сургуулиар эзэмшүүлэх “Эрүүл мэнд”-ийн боловсролын талаар үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, Эрүүл мэндийн боловсрол, анагаах ухааны чиглэлээр 2003-2006 онд хэрэгжүүлэх стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг БСШУ болон Эрүүл мэндийн сайдын 2003 оны 188/143 дугаар хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлсэн билээ.

Үүний үр дүнд ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх чиглэлээр бодлогын хүрээнд дараах эрхзүйн баримт бичгүүд батлагдан хэрэгжсэн. Үүнд:

- 1998-1999 оны хичээлийн жилээс Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-д эрүүл мэндийн хичээл анх албан ёсоор орох болсон;

- 2002-2003 оны хичээлийн жилээс ЕБС-ийн нийт суралцагч жил бүр 34-36 цагийн эрүүл мэндийн хичээл судлах болсон;
- 2004 онд Эрүүл мэндийн боловсролын стандарт батлагдсан;
- Багш нар стандартад суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх болсон;
- ЕБС-ийн анги бүрт судлах сурагчийн сурах бичгүүд, бусад сургалтын хэрэглэгдэхүүн хэвлэгдэн гарсан.

Үүний зэрэгцээ МУБИС, түүний харьяа сургуулиудад эрүүл мэндийн багш бэлтгэх асуудлыг институтчилж, эрүүл мэндийн багшийн хавсарсан анги нээсэн.

Түүнчлэн НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх Глобал сан, АДРА Монгол Олон улсын байгууллага, Норвегийн тусламжийн байгууллага зэрэг олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн боловсролыг хөгжүүлэх чиглэлээр багш бэлтгэх, сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтын хэрэглэгдэхүүн гарын авлага боловсруулан түгээх, үе тэнгийн сургагч бэлтгэх зэрэг үйл ажиллагааг тус тус зохион байгуулсан.

Эрүүл мэндийн боловсролын өнөөгийн байдалд үнэлгээ, дүгнэлт өгөх хэд, хэдэн судалгаа, үнэлгээ хийгдсэнээс дурдвал:

- Глобал сангийн дэмжлэгтэй “Сургуулийн боловсрол” дэд төслийн хүрээнд хийгдсэн *“БЗДХ, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх талаарх хүүхэд өсвөр үеийнхний мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлох”* судалгаа (2005),
- НҮБ-ын ХАС-ийн Өсвөр үеийн төслийн хүрээнд хийсэн *“ЕБС-ийн эрүүл мэндийн сургалтын өнөөгийн байдал”* судалгаа (2008),
- ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр хийгдсэн *“ХДХВ ба ДОХ-ын асуудалд боловсролын салбарын бэлэн байдал, хариу арга хэмжээ”*-ний талаарх хөндлөнгийн үнэлгээ (2009) зэрэг болно.

Дээрх судалгааны тайланд ЕБС-иар дамжуулан эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх асуудлыг цогцоор нь хэрэгжүүлэхэд багагүй амжилт олсныг онцлон тэмдэглэсэн байна. Тухайлбал:

- Албан боловсролын хүрээнд ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөнд эрүүл мэндийн хичээл заавал судлах хичээл болж орж, цаг нь нэмэгдсэн;
- Эрүүл мэндийн боловсролын стандарт батлагдсан;
- Багш бэлтгэх сургалтууд зохион байгуулагдсан;
- Сургалтын хөтөлбөр, материал, гарын авлага, сурах бичгүүд боловсруулагдсан зэрэг нь бага, дунд боловсролын салбарт эрүүл мэндийн боловсролыг дэмжих орчин бүрдэж байгааг харуулж байна.

Албан бус боловсролын хүрээнд иргэдэд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх (2005), сургуулийн гадна байгаа хүүхэд, залууст ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх дүйцсэн хөтөлбөрөөр эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх (2006), ХДХВ/ДОХ/БЗДХ-аас сэргийлэх (2007) зэрэг хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлсэн байна.

Мөн эрүүл мэндийн боловсролын хэрэгжилтэд дараах тулгамдсан асуудал, бэрхшээл байгааг судалгааны тайлангуудад дурджээ. Тухайлбал: эрүүл мэндийн боловсролын стандартыг амжилттай хэрэгжүүлэхэд энэ чиглэлээр мэргэшсэн багш дутмаг, суралцагчдын хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөр, сурах бичгийн чанар, хүртээмж хангалтгүй, сургалтын орчин төдийлөн сайн бүрдээгүй зэрэг тулгамдсан асуудлаас гадна эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй, давхардалт их, хөрөнгө мөнгөний хуваарилалт, үр дүнгийн үнэлгээ бараг хийгддэггүй гэсэн дүгнэлт гарсан байна.

Түүнчлэн зөвхөн ЕБС төдийгүй Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийн суралцагчид, сургууль завсардсан хүүхэд залуус, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийт хүн амд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх асуудлыг цогцоор нь авч хэрэгжүүлэх хэрэгцээ үүсч байна.

Сүүлийн 15 жилийн турш хүний эрсдэлт зан үйл, хүрээлэн буй орчинтой холбоотой халдварт бус өвчний улмаас нас баралтын шалтгаанд зүрх судасны өвчин, чихрийн шижин, ясны сийрэгжилт, хавдар болон эдгээр өвчнийг нөхцөлдүүлэгч завсрын хүчин зүйл болох таргалалт, цусны даралт ихсэлт, цусан дахь өөх тос, сахарын хэмжээ нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал: Монгол улсын хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгааныг 10000 хүн амд ногдох байдлаар авч үзэхэд цусны

эргэлтийн тогтолцооны өвчин, хавдар, бэртэл хордлого гадны шалтгаант үр дагавар, хоол шингээх эрхтний өвчин болон амьсгалын тогтолцооны эмгэг эзэлж байгаа бөгөөд цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл 15-45 насныхны дунд түгээмэл байна.

Гэвч өвчлөлийн хувьд халдварт өвчин тэргүүлсэн хэвээр байна. Мөн шинээр болон дахин сэргэж байгаа халдварт өвчний тархалт, давтамж нэмэгдэж, зарим халдварт өвчин цар тахлын хэмжээнд хүрч байгаа нь анхаарал хандуулах асуудал болж байна. Сүүлийн жилүүдэд амиа хорлох, хүчирхийлэлд өртсөнөөс болж амь насаа алдах тохиолдлын тоо нэмэгдэж байна.

Өвчлөлийн дийлэнх нь хүн амын ихээхэн хэсгийг эзэлдэг (0-19 насны хүмүүс нийт хүн амын 47%) хүүхэд, залуус болон ядуу, эмзэг бүлгийнхэнд ногдож байгаа юм. Түүнчлэн нийт хүн амын 40 хувийг эзэлж байгаа 20-44 насны хүмүүсийн өвчлөлийн байдлыг авч үзэхэд, эрчүүдэд гэмтэл, бэртэл, хордлого давамгайлж байхад эмэгтэйчүүдэд жирэмслэлтэй холбоотой эмгэг, шээс бэлгийн замын өвчин зонхилон тохиолдож байна.

2009 оны 12 сарын байдлаар ХДХВ-ийн халдварын 61 тохиолдлыг албан ёсоор бүртгээд байгаа ба Монгол улс ХДХВ ба ДОХ-ын тархалт багатай орны ангилалд ордог хэдий ч халдварын цартахал нийт хүн амд хурдацтай тархах нөхцөл бүрдүүлсэн хэд хэдэн эрсдэлт хүчин зүйл оршсоор байна. Тухайлбал: БЗДХ-ын тархалт өндөр, тэр дундаа БЗДХ-тай бүртгэгдсэн хүмүүсийн 50 орчим хувийг 24 хүртэлх насны өсвөр үе, залуучууд эзэлдэг, насанд хүрэгчид болон залуучуудын дунд бэлгийн эрсдэлт зан үйл давамгайлж байгаа, газар зүйн байршлаараа халдварын тархалт ихтэй 2 гүрний дунд оршдог зэрэг нь нийт хүн ам тэр дундаа өсвөр үе, залуучуудад урьдчилан сэргийлэх цогц мэдлэг, ур чадвар, эерэг хандлага төлөвшүүлэх хэрэгтэй байгааг илтгэнэ.

Монгол улс одоогоор ХДХВ-ийн тархалт багатай боловч эрсдэл өндөртэй орны тоонд орж байгаа нөхцөлд өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн цогц боловсрол эзэмшүүлэхэд, тэр дундаа ХДХВ ба ДОХ-оос сэргийлэх асуудалд анхаарах шаардлага гарч байна. Мөн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, нийт хүн амын дунд дэлхийн дулаарлаас шалтгаалан халдварт өвчлөлийн давтамж нэмэгдэж байгаа нь ард иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

Гурав. Стратеги төлөвлөгөөний зорилго

Амьдрах ухаанд суурилсан эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэхэд чиглэсэн бодлогын хүрээг тогтоож, хэрэгжилтэд төрийн ба төрийн бус байгууллага, гадаад орон, олон улсын байгууллагын оролцоонд тулгуурласан өргөн хүрээтэй хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэхэд оршино.

Дөрөв. Стратеги төлөвлөгөөний зорилтууд:

1. Эрүүл мэндийн боловсролын талаар баримталж буй бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, салбаруудын үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж, тогтвортой хөгжлийн боловсролын үйл хэрэгт бодит хувь нэмэр оруулах;
2. Олон улсын жишигт нийцсэн, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг баримжаалсан амьдрах ухаанд суурилсан эрүүл мэндийн боловсролын стандарт, хөтөлбөрийг сайжруулан боловсруулж хэрэгжүүлэх;
3. Эрүүл мэндийн боловсролын үйлчилгээний менежментийг боловсронгуй болгож, эрүүл мэндийн боловсролын асуудал хариуцсан хүний нөөцийн чадавхийг бүх төвшинд нэмэгдүүлэх;
4. Албан ба албан бус боловсролын бүх төвшний байгууллагаар дамжуулан нийт хүн амд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх ээлтэй орчин бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын материал, хэрэглэгдэхүүнээр хангах;
5. Эрүүл мэндийн боловсролыг дэмжих ухуулга нөлөөллийн үйл ажиллагаа, зан үйлийг өөрчлөх мэдээлэл сургалт сурталчилгааны төрөл, чанарыг сайжруулж, насанд туршдаа эрүүл мэндийн боловсрол эзэмших нөхцөл боломжийг нэмэгдүүлэх;
6. Эрүүл мэндийн боловсролын төвшин тогтоох, өсвөр үе, залуучуудын зан үйлийн төлөвшлийг үнэлэх аргазүй боловсруулан, хяналт шинжилгээг тогтмолжуулах, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх.

Тав. Хэрэгжүүлэх зарчим

Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Олон улсын болон боловсролын салбарын хөгжлийн бодлого, стратегитэй уялдуулах
- Талуудын хамтын оролцоонд тулгуурлах
- Тэгш хүртээмжтэй байх
- Эрүүл мэндийн боловсролын хэрэгцээ, агуулга, аргазүй нь суралцагчийн нас, бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийн онцлогт тохирсон байх
- Хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хангасан байх
- Үндэсний болон цөөнхийн онцлог хэрэгцээ (уламжлал, соёл, зан заншил)-г хүндэтгэсэн байх

Зургаа. Хугацаа

Стратеги төлөвлөгөө нь 2010-2015 онд хэрэгжинэ.

Долоо. Санхүүжилт

- Улсын төсөв
- Гадаад, дотоодын байгууллагын хандив, тусламж
- Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

Найм. Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

Зорилт 1: Эрүүл мэндийн боловсролын талаар баримталж буй бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, салбаруудын үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж, тогтвортой хөгжлийн боловсролын үйл хэрэгт бодит хувь нэмэр оруулах

Үйл ажиллагааны чиглэл:

- 1.1 Эрүүл мэндийн боловсролын чиглэлээр хэрэгжүүлж буй тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, сайжруулах;
- 1.2 Сургуулийн өмнөх боловсролын хүрээнд эрүүл мэндийн мэдлэг, чадвар төлөвшүүлж буй өнөөгийн байдалд үнэлгээ өгөх, зөвлөмж гаргаж хэрэгжүүлэх,
- 1.3 МСҮТ-үүдэд эрүүл мэндийн хичээлийг судлах эрх зүйн орчин бүрдүүлж, сургалтын төлөвлөгөөнд оруулах бодлогын шийдвэр гаргах хэрэгжүүлэх;
- 1.4 Эрүүл мэндийн хичээлийг стандарт үнэлгээтэй болгох асуудлыг судалж шийдвэрлэх;
- 1.5 Багш, суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах заалтуудыг сургуулийн дотоод дүрэм журамд оруулах үлгэрчилсэн чиглэл боловсруулж ЕБС-иудыг арга зүйн удирдлагаар хангах;
- 1.6 Эрүүл мэндийг дэмчигч сургууль, цэцэрлэг болох хөдөлгөөн өрнүүлэх;
- 1.7 Эрүүл мэндийн боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаад, дотоодын төрийн ба төрийн бус байгууллагуудын сүлжээ байгуулж, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.

Зорилт 2: Олон улсын жишигт нийцсэн, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг баримжаалсан амьдрах ухаанд суурилсан эрүүл мэндийн боловсролын стандарт, хөтөлбөрийг сайжруулан боловсруулж, хэрэгжүүлэх

Үйл ажиллагааны чиглэл

- 2.1 Эрүүл мэндийн боловсролын агуулга, арга зүйд тогтвортой хөгжлийн үзэл санаа, агуулга, аргазүйн үүднээс үнэлгээ өгч сайжруулах;
- 2.2 Эрүүл мэндийн бага, дунд боловсролын стандартыг шинэчлэн боловсруулах, батлуулах;
- 2.3 ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрийг анги тус бүрээр боловсруулах, сайжруулах, хэрэгжилтийг арга зүйн удирдлагаар хангах;
- 2.4 МСҮТ-ийн сургалтын төлөвлөгөөнд эрүүл мэндийн хичээл оруулах ухуулга нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх, бэлтгэл ажлыг хангах;
- 2.5 МСҮТ-д судлах эрүүл мэндийн сургалтын модуль боловсруулж, хэрэгжүүлэх;

2.6 Албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх модульт хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.

Зорилт 3: Эрүүл мэндийн боловсролын үйлчилгээний менежментийг боловсронгуй болгож, эрүүл мэндийн боловсролын асуудал хариуцсан хүний нөөцийн чадавхийг бүх төвшинд нэмэгдүүлэх

Үйл ажиллагааны чиглэл

3.1 ЕБС-ийн эрүүл мэндийн хичээл заах багш бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр хүний нөөцийг нэмэгдүүлэх;

3.2 МСҮТ-д эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх хүний нөөцийг бүрдүүлэх;

3.3 МУБИС, түүний харъяа багш бэлтгэдэг дээд сургуулиудын эрүүл мэндийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, шинээр бэлтгэх;

3.4 МУБИС, түүний харъяа сургуулиудад эрүүл мэндийн мэргэжлийн багш бэлтгэх анги, элсэлтийг нэмэгдүүлэх;

3.5 Аймаг, нийслэлийн Боловсрол Соёлын Газар (БСГ)-ыг түшиглэн эрүүл мэндийн боловсролыг хөгжүүлэх хүний нөөц бүрдүүлэх орон нутгийн тогтолцоог бий болгох;

3.6 Иргэд, хүүхэд, залууст эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх АББ-ын багш нарыг сургагч багшаар бэлтгэх.

Зорилт 4: Албан ба албан бус боловсролын бүх төвшний байгууллагаар дамжуулан нийт хүн амд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх ээлтэй орчин бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын материал, хэрэглэгдэхүүнээр хангах

Үйл ажиллагааны чиглэл

4.1 ЕБС-ийн 1-12 дугаар ангийн эрүүл мэндийн хичээлийн сурагчийн сурах бичиг болон багшийн зөвлөмж боловсруулах, хэвлэх, түгээх;

4.2 ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлд ашиглагдах үзүүлэн, аудио, видео материал боловсруулах, түгээх, ашиглалтад хяналт тавих;

- 4.3 Эрүүл мэндийн боловсролын чиглэлээр МСҮТ болон багш бэлтгэдэг их дээд сургуулийн багш, оюутнуудад зориулсан гарын авлага, холбогдох бусад хэрэглэгдэхүүнийг боловсруулах, хэвлэх, түгээх;
- 4.4 Албан бус боловсролын төвөөр дамжуулан иргэдэд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх сургалтын орчин бүрдүүлэх, хэрэглэгдэхүүн нэмж боловсруулан ашиглах;
- 4.5 ЕБС, МСҮТ, багш бэлтгэдэг их дээд сургуулиудад эрүүл мэндийн кабинет, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төв байгуулах;
- 4.6 Цэцэрлэг, сургуулийн эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах;
- 4.7 Хувь хүний зан үйлтэй холбоотой өвчлөл, буруу зуршлын шалтгааныг судалж тогтоох, сайжруулах арга замыг тодорхойлох, хэрэгжүүлэх

Зорилт 5: Эрүүл мэндийн боловсролыг дэмжих ухуулга нөлөөллийн үйл ажиллагаа, зан үйлийг өөрчлөх мэдээлэл сургалт сурталчилгааны төрөл, чанарыг сайжруулж, насанд туршдаа эрүүл мэндийн боловсрол эзэмших нөхцөл боломжийг нэмэгдүүлэх

Үйл ажиллагааны чиглэл

- 5.1 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад эрүүл мэндийн боловсрол олгоход хэрэглэгдэх сургалтын материал боловсруулах, хэвлэх, түгээх
- 5.2 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудад ашиглагдаж буй сургалтын материалуудад үнэлгээ өгөх замаар эрүүл мэндийн хичээлд хэрэглэх нэмэлт материалын хэрэгцээг тодорхойлох;
- 5.3 Нийт хүн ам, ялангуяа хүүхэд, өсвөр насныханд зориулсан эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэхэд мэдээлэл, харилцааны технологийн дэвшлийг ашиглах боломжийг нэмэгдүүлэх;
- 5.4 Хүүхэд залуучуудад эрүүл мэндээ хамгаалах эрсдэлгүй зан үйл төлөвшүүлэх чиглэлээр ухуулга, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өргөжүүлэх;

5.5 Хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн цогц мэдээллийг хүргэдэг арга, хэрэгсэл ашиглан тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх;

5.6 Иргэд олон нийтэд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх сургалтын аудио, видео материал боловсруулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан олон нийтэд хүргэх

Зорилт 6: Эрүүл мэндийн боловсролын төвшин тогтоох, өсвөр үе, залуучуудын зан үйлийн төлөвшлийг үнэлэх арга зүй боловсруулан, хяналт шинжилгээг тогтмолжуулах, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх

Үйл ажиллагааны чиглэл

6.1 Эрүүл мэндийн боловсролын талаар мэдээлэл авч боловсролын статистик мэдээллийн тогтолцоонд оруулдаг болох;

6.2 Хүүхэд, өсвөр үе, залуучуудын нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн эрүүл мэндийн зан үйлийн чадвар, дадлыг үнэлэх арга зүйг боловсруулан турших, хэрэгжүүлэх.

Ес. Хяналт, шинжилгээ-үнэлгээ, шалгуур үзүүлэлт

Стратеги төлөвлөгөөний салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг нь төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг үнэлэх хяналт-шинжилгээний ажил болно.

Хяналт-шинжилгээ нь дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны ахиц, дэвшил (үзүүлсэн үйлчилгээ, бий болгосон чадавхи, нөөц бололцоо)-д хяналт-шинжилгээ хийх төдийгүй хүүхэд, залуучуудын эрүүл мэндийн боловсролын талаарх мэдлэг, хандлага, зан үйлд гарсан өөрчлөлт (үр нөлөө)-ийг хянахад чиглэнэ.

БСШУЯ-наас стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шат бүрт хийгдэх хяналт-шинжилгээний төрлийг тогтоож, холбогдох талуудтай хамтран хяналт-шинжилгээг хийнэ.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

Чанарын үнэлгээний үзүүлэлтүүд:

- Эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх удирдлага, менежмент, бодлого, эрх зүйн орчин, үйл ажиллагааны дэмжлэг бий болсон байдал
- Эрүүл мэндийн боловсролын үйлчилгээний уян хатан, тасралтгүй, нээлттэй, хүртээмжтэй, таатай орчин бүрдсэн байдал (сургалтын тогтолцоо, үйлчилгээний хэлбэр түүний хүртээмж, хамрах хүрээ, хэрэгцээг хангаж буй байдал, хүний нөөцийн болон багшлах боловсон хүчний чадавхи, сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйн чанар, сургалтын цагийн багтаамж, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж, түүний төрөл, ашиглалтын байдал)
- Эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрт **зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчин**, ХДХВ, БЗДХ-аас сэргийлэх, амьдрах ухаан, бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендерийн тэгш байдал, мансууруулах бодис хэрэглэх, **аюул ослоос** урьдчилан сэргийлэх зэрэг бусад холбогдох сэдвийг багтаасан байдал
- Эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх үйл явц, үр дүнгийн талаарх удирдлага, мэдээллийн нэгдсэн систем, мэдээллийн сан бүрдсэн байдал
- Эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх үйлчилгээнд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж буй байдал
- Эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэхэд олон нийтийн оролцоо, нийгмийн түншлэлийг бий болгосон байдал (стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудын оролцоо, түүний үр дүнд санхүүгийн болон хүний нөөцийн, бусад нөөцийн эх үүсвэрийг бий болгосон байдал, олон нийт, нийгмийн түншлэлд тулгуурласан тогтвортой, байнгын үйл ажиллагааны бүтэц бүрэлдсэн байдал, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд түүний үзүүлсэн үр нөлөө) бий болсон байдал
- Сургууль, анги танхимд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх нийгэм, сэтгэл зүйн таатай орчин бүрдсэн байдал

Тоон үнэлгээний үзүүлэлтүүд:

- Эрүүл мэндийн хичээл заах бэлтгэгдсэн багшийн тооны өсөлт
- Эрүүл мэндийн боловсролын асуудлаар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан багшийн тооны өсөлт/сургагч багш
- Эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх сургалтад хамрагдсан хүүхэд, залуучуудын тооны өсөлт
- Эрүүл мэндийг дэмжигч сургууль, цэцэрлэгийн тооны өсөлт
- Эрүүл мэндийн сургалтын орчин бүрдсэн сургалтын байгууллагын тооны өсөлт
- Хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн боловсролын асуудлаар сургалт, зөвлөгөө өгөх материаллаг бааз бүхий танхимын тоо
- Хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудад зориулсан эрүүл мэндийн боловсролын сургалтын материал, гарын авлага, үзүүлэн таниулах /аудио, видео/ материалын тоо, хүртээмж
- Хүүхэд, өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулсан ухуулга, сурталчилгаа, нөлөөллийн ажлын тооны өсөлт
- Эрүүл мэндийн боловсролд зарцуулсан санхүүжилт, түүний үр ашиг (он, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалт, хөрөнгийн хэмжээ)

---- 000 ----

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2010 оныдугаар сарынны өдрийн хамтарсандугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫН ТАЛААР 2010-2015 ОНД БАРИМТЛАХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга, хэлбэр	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах төсөв (сая төгрөг)	Хугацаа					
						2010	2011	2012	2013	2014	2015
Зорилт 1. Эрүүл мэндийн боловсролын талаар баримталж буй бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, салбаруудын үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж, тогтвортой хөгжлийн боловсролын үйл хэрэгт бодит хувь нэмэр оруулах											
Гарах үр дүн: Ерөнхий боловсролын сургууль, МСҮТ-д эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх эрх зүйн орчин сайжирч, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хамтын ажиллагаа нэмэгдэнэ.											
Шалгуур үзүүлэлт: - Эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх удирдлага, менежмент, бодлого, эрх зүйн орчин, үйл ажиллагааны дэмжлэг бий болсон байдал - Эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэхэд олон нийтийн оролцоо, нийгмийн түншлэл (стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын оролцоо, түүний үр дүнд санхүүгийн болон хүний нөөцийн, бусад нөөцийн эх үүсвэрийг бий болгосон байдал, олон нийт, нийгмийн түншлэлд тулгуурласан тогтвортой, байнгын үйл ажиллагааны бүтэц бүрэлдсэн байдал, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд түүний үзүүлсэн үр нөлөө) бий болсон байдал											
1.1	Эрүүл мэндийн боловсролын чиглэлээр хэрэгжүүлж буй тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, сайжруулах	Хүчин төгөлдөр мөрдөж буй тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх ажлын хэсэг байгуулах, засан сайжруулах ажлыг зохион байгуулах	БСШУЯ	эмя							

1.2	МСҮТ-үүдэд эрүүл мэндийн хичээлийг судлах эрх зүйн орчин бүрдүүлж, сургалтын төлөвлөгөөнд оруулах бодлогын шийдвэр гаргаж хэрэгжүүлэх	МСҮТ-ийн сургалт, арга зүйн төвтэй хамтран үндэслэл, бусад холбогдох эрх зүйн актын төсөл боловсруулж батлуулах	БСШУЯ	эмя	2							
1.3	Эрүүл мэндийн хичээлийг стандарт үнэлгээтэй болгох асуудлыг судалж шийдвэрлэх	ЕБС-ийн суралцагчийн үнэлгээний журамд уг асуудлыг тусгах үндэслэл боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах	БСШУЯ	ЭМЯ								
1.4	Багш, суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах заалтуудыг сургуулийн дотоод дүрэм журамд оруулах үлгэрчилсэн чиглэл боловсруулан батлуулж, ЕБС-иудыг арга зүйн удирдлагаар хангах	"Сургуулийн дотоод журам"-ын боловсруулалтын өнөөгийн байдалд үнэлгээ өгөх, үлгэрчилсэн журмын төслийг боловсруулж хэлэлцүүлэх, батлуулах, аргазүйн удирдамж боловсруулж бүх сургуульд хүргүүлэх	БСШУЯ	ЭМЯ, аймаг, нийслэлийн БСГ								
1.5	Эрүүл мэндийг дэмжигч сургууль, цэцэрлэг болох хөдөлгөөн өрнүүлэх	Уралдааны болзлыг шинэчлэх	ЭМЯ, ЗГХА-ЭМГ	БСШУЯ, ММССан								
		Жил бүр шалгаруулалт хийж байх	ЭМЯ, ЗГХА-ЭМГ	БСШУЯ, ММССан	50,0	*	*	*	*	*		

1.6	Эрүүл мэндийн боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаад, дотоодын төрийн ба төрийн бус байгууллагуудын сүлжээ байгуулж, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах	БСШУЯ-ны манлайлал дор эрүүл мэндийн боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын сүлжээ бий болгох, дүрмээ зөвшилцөж батлах	БСШУЯ	ЭМЯ бусад байгууллага								
		Сүлжээний байгууллагуудын уулзалтыг улирал бүр тогтмол явуулдаг болох			300,0							

Зорилт 2. Олон улсын жишигт нийцсэн, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг баримжаалсан амьдрах ухаанд суурилсан эрүүл мэндийн боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг сайжруулан боловсруулж хэрэгжүүлэх

Гарах үр дүн: Ерөнхий боловсролын сургууль, МСҮТ-д суралцагчид олон улсын жишигт нийцсэн амьдрах ухаанд суурилсан, эрүүл мэндийн боловсролын стандарт, хөтөлбөрөөр хичээллэх боломж бүрдэнэ.

Шалгуур үзүүлэлт - Эрүүл мэндийн хичээлийн сургалтын хөтөлбөрт зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчин, ХДХВ, БЗДХ-аас сэргийлэх, амьдрах ухаан, бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендерийн тэгш байдал, мансууруулах бодис хэрэглэх, аюул ослоос урьдчилан сэргийлэх зэрэг бусад холбогдох сэдвүүдийг багтаасан байдал - Эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх сургалтад хамрагдсан хүүхэд, залуучуудын тооны өсөлт												
2.1	Эрүүл мэндийн боловсролын агуулга, аргазүйд тогтвортой хөгжлийн үзэл санаа, агуулга, аргазүйн үүднээс үнэлгээ өгч сайжруулах;	Эрүүл мэндийн боловсролын агуулга, аргазүйн хэрэгжилтэд судалгаа хийх	БСШУЯ-ны Ерөнхий Боловсролын Газар (ЕБГ)	Боловсролын Хүрээлэн,ЗГХ А-ЭМГ Ажлын хэсэг								
		Агуулга аргазүйг сайжруулах зөвлөмж боловс руулах			5,0							
2.2	Эрүүл мэндийн бага, дунд боловсролын стандартыг шинэчлэн боловсруулах,	Бага, дунд боловсролын эрүүл мэндийн стандартыг боловсруулах, хэлэлцүүлэх	БСШУЯ-ны Ерөнхий Боловсролын Газар	ЭМЯ, ММССан, Боловсролын Хүрээлэн,	15,0							

	батлуулах	Эрүүл мэндийн стандартыг турших, сайжруулан эцэслэх батлуулах	(ЕБГ)	Ажлын хэсэг	20,0							
2.3	ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрийг анги тус бүрээр боловсруулах, сайжруулах, хэрэгжилтийг аргазүйн удирдлагаар хангах	Анги тус бүрийн агуулгыг тодорхойлж, хөтөлбөр боловсруулах, хэлэлцүүлэх	БСШУЯ-ны ЕБГ	Боловсролын Хүрээлэн, ЭМЯ,ММССан Ажлын хэсэг	10,0							
		Хөтөлбөрийг турших сайжруулах, хэрэгжилтэд үнэлгээ өгөх			5,0							
2.4	МСҮТ-ийн сургалтын төлөвлөгөөнд эрүүл мэндийн хичээл оруулах, ухуулга нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх, бэлтгэл ажлыг хангах	Эрүүл мэндийн хичээл оруулах үндэслэл боловсруулах ажлын хэсэг байгуулах	БСШУЯ-ны Мэргэжлийн Боловсролын Газар (МБГ)	ЮНЕСКО, Мэргэжлийн Боловсролын сургалт, аргазүйн төв (МБСАЗТ)								
		Ажлын хэсгийн тайланг хэлэлцүүлэх, сургалтын төлөвлөгөөнд оруулахаар батлуулах			2,0							
2.5	МСҮТ-д судлах эрүүл мэндийн сургалтын модульт хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	МСҮТ-д судлах агуулгыг тогтоож, сургалтын хөтөлбөр (модуль) боловсруулах хэлэлцүүлэх, турших,	БСШУЯ-ны МБГ	ЮНЕСКО, МБСАЗТ, Ажлын хэсэг	9,0							
		Хөтөлбөрийг сайжруулах, хэрэгжүүлэх, үнэлгээ өгөх			5,0							
2.6	Албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх модульт хөтөлбөр боловсруулж,	Дүйцсэн хөтөлбөрөөр эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр бага, суурь, бүрэн дунд боловсролын төвшингөөр боловсруулах, турших	БСШУЯ-ны ЕБГ	ЭМЯ, ММССан, ЮНИСЕФ, АББЗСҮТ Ажлын хэсэг	8,0							

3.2	МСҮТ-д эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх хүний нөөцийг бүрдүүлэх	МСҮТ-д эрүүл мэндийн хичээл заах багш бэлтгэх модульт хөтөлбөр боловсруулах	БСШУЯ-ны МБГ	ЮНЕСКО, МБСАЗТ, Сургагч багшийн баг	9,0							
		Эрүүл мэндийн багш бэлтгэх сургалт зохион байгуулах			36,0							
3.3	МУБИС, түүний харъяа багш бэлтгэдэг дээд сургуулиудын эрүүл мэндийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, шинээр бэлтгэх	Эрүүл мэндийн боловсролын чиглэлээр амжилттай ажиллаж буй улс орноос мэргэжилтэн урьж ажиллуулах	БСШУЯ	Олон улсын байгууллага, МУБИС	30,0							
		Эрүүл мэндийн хичээл заах багш нарыг нэмж бэлтгэх										
		Эрүүл мэндийн боловсролын чиглэлээр амжилттай ажиллаж буй улс орнуудад багш нарыг явуулж туршлага судлуулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх			60,0							
3.4	МУБИС, түүний харъяа сургуулиудад эрүүл мэндийн мэргэжлийн багш бэлтгэх анги, элсэлтийг нэмэгдүүлэх	МУБИС-д одоо хэрэгжиж буй сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах	БСШУЯ-ны ЕБГ, МБГ	НҮБ-ын ХАС, МУБИС, Боловсролын Хүрээлэн	8,0							
		Эрүүл мэндийн багшийн шинэ хослол бүхий анги нээж ажиллуулах талаарх боломж нөхцлийг судлах										
		БСШУЯ-аас тусгай зөвшөөрөл авах эрхзүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах										

3.5	Аймаг, нийслэлийн Боловсрол Соёлын Газар (БСГ)-ыг түшиглэн эрүүл мэндийн боловсролыг хөгжүүлэх хүний нөөц бүрдүүлэх орон нутгийн тогтолцоо бий болгох	Аймаг, нийслэлийн БСГ-ийн эрүүл мэндийн боловсрол хариуцсан арга зүйчийг чадавхжуулах, орон нутгийн баг бүрдүүлэх боломж, хүний нөөцийг судлах	БСШУЯ-ны ЕБГ	Боловсролын Хүрээлэн, МУБИС, Ажлын хэсэг	30,0							
		Эрүүл мэндийн арга зүйчдийг мэргэшүүлэн бэлтгэх сургалт зохион байгуулах			35,0							
		Сургалтын хөтөлбөр боловсруулах			10,0							
		Аймаг, орон нутагт бүсчилсэн сургалт явуулах			45,0							
3.6	Иргэд, хүүхэд, залууст эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх АББ-ын багш нарыг сургагч багшаар бэлтгэх	Сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулах	БСШУЯ-ны ЕБГ	ЗГХА-ЭМГ, ММССан, АББЗСҮТ	5,0							
		АББ-ын багш нарыг сургагч багшаар бэлтгэх сургалт зохион байгуулах, давтан бэлтгэх			10,0							

Зорилт 4: Албан ба албан бус боловсролын бүх төвшний байгууллагаар дамжуулан нийт хүн амд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх ээлтэй орчин бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын материал, хэрэглэгдэхүүнээр хангах

Гарах үр дүн: Хүн амд эрүүл мэндийн боловсролын үйлчилгээ үзүүлэх сургалтын ээлтэй орчин бүрдсэнээр хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндээ хамгаалах хандлагад эерэг өөрчлөлт гарна.

- Шалгуур үзүүлэлт:**
- Эрүүл мэндийн сургалтын орчин бүрдсэн сургалтын байгууллагын тооны өсөлт
 - Хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн боловсролын асуудлаар сургалт, зөвлөгөө өгөх материаллаг бааз бүхий танхимын тоо

- Хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудад зориулсан эрүүл мэндийн боловсролын сургалтын материал, гарын авлага, үзүүлэн таниулах /аудио, видео/ материалын тоо, хүртээмж

4.1	ЕБС-ийн 1-12 дугаар ангийн эрүүл мэндийн хичээлийн сурагчийн сурах бичиг болон багшийн зөвлөмж боловсруулах, хэвлэх, тараах	ЕБС-ийн бага ангийн эрүүл мэндийн сурагчийн сурах бичиг, багшийн номыг бэлтгэх, хэвлэх, түгээх	БСШУЯ -ны ЕБГ	ЭМЯ, Боловсролын Хүрээлэн Ажлын хэсэг	150,0						
		ЕБС-ийн дунд ангийн эрүүл мэндийн сурагчийн сурах бичиг, багшийн номыг бэлтгэх, хэвлэх, түгээх			150,0						
		ЕБС-ийн ахлах ангийн эрүүл мэндийн сурагчийн сурах бичиг, багшийн номыг зохиох, хэвлэх, түгээх			100,0						
4.2	ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлд ашиглагдах үзүүлэн, аудио, видео материал боловсруулан бэлтгэх, түгээх, ашиглалтад хяналт тавих	Сурах бичиг, гарын авлага, МСС-ны материалуудад хяналт шинжилгээ хийж, нэмэлт материалын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох	БСШУЯ-ны ЕБГ	ЭМЯ, ММССан Боловсролын Хүрээлэн, Ажлын хэсэг	30,0						
		Мэдээллийн самбар ажиллуулах болон МСС-ны материалын төрөл хэлбэрийг сайжруулах, ашиглалтыг нэмэгдүүлэх			10,0						
		Сурагчийн ажлын дэвтэр зэрэг бусад хэвлэмэл нэмэлт материал болон аудио, видео нөөц хэрэглэгдэхүүн боловсруулах, орчуулах,			15,0						

		хэвлэх, тараах											
4.3	Эрүүл мэндийн боловсролын чиглэлээр МСҮТ болон багш бэлтгэдэг их дээд сургуулийн багш, оюутнуудад зориулсан гарын авлага, холбогдох бусад хэрэглэгдэхүүнийг боловсруулах, хэвлэх, түгээх	Багш болох оюутанд зориулсан гарын авлага бэлтгэж, хэвлэх	БСШУЯ-ны МБГ, ЕБГ	ЭМЯ, ММССан, Боловсролын Хүрээлэн, МУБИС	10,0								
		Багш бэлтгэдэг их дээд сургуулийн багш нарт зориулсан нэмэлт ашиглах аудио, видео, хэвлэмэл материал орчуулах, боловсруулж, хэвлэх			5,0								
		МСҮТ-ийн суралцагчдын хэрэгцээг судалж, түүнд нийцсэн гарын авлага, бусад хэрэглэгдэхүүн боловсруулах, турших,	БСШУЯ-ны МБГ	МБСАЗТ ЮНЕСКО	10,0								
		Гарын авлага хэрэглэгдэхүүнийг хэвлэх, түгээх, үнэлгээ хийх			10,0								
4.4	Албан бус боловсролын төвөөр дамжуулан иргэдэд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх сургалтын орчин бүрдүүлэх, хэрэглэгдэхүүн нэмж боловсруулан ашиглах	Одоо ашиглагдаж буй сургалтын материалуудад дүн шинжилгээ хийж, нэмэлт материалын хэрэгцээг тодорхойлох	БСШУЯ-ны ЕБГ	АББЗСҮТ, ЮНЕСКО, ЮНИСЕФ, ЗГХА-ЭМГ ММССан	10,0								
		Ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалттай уялдан АББ-ын Гэгээрэл төвийг ЕБС-д ашигладаг сургалтын материал, үзүүлэн,			35,0								

		хэрэглэгдэхүүнээр хангах									
		Албан бусын багшид зориулсан нэмэлт ашиглах материал боловсруулж, хэвлэх, түгээх			12,0						
		Суралцагчдад зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн, үзүүлэн, тарааж өгөх материал бэлтгэх, тараах			18,0						
4.5	ЕБС, МСҮТ, багш бэлтгэдэг их дээд сургуулиудад эрүүл мэндийн кабинет, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төв байгуулах	ЕБС, багш бэлтгэдэг болон бусад их дээд сургууль болон сургуулийн дотуур байранд эрүүл мэндийг дэмжих ээлтэй орчин бүрдүүлэх	БСШУЯ	НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд АДРА Монгол, ЭМЯ, ЗГХА-ЭМГ, ММССан	150,0						
		ЕБС-уудын эрүүл мэндийн сургалтын кабинетад тавигдах шаардлага стандарт, үлгэрчилсэн дүрмийг боловсруулах мөрдөх	БСШУЯ-ны ЕБГ	ЭМЯ, Боловсролын Хүрээлэн, Нийслэлийн БСГ, ММССан	3,5						
		МУБИС-д эрүүл мэндийн кабинет байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглох, кабинетийн үлгэрчилсэн дүрмийг боловсруулж мөрдөх	БСШУЯ	МУБИС	15,0						

4.6	Цэцэрлэг, сургуулийн эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	Эрүүл мэндийг дэмжих сургууль цэцэрлэг шалгаруулах болзлыг шинэчлэн боловсруулж, батлуулах	БСШУЯ	ЭМЯ, ЗГХА-ЭМГ, Аймаг нийслэлийн БСГ, ММССан	30,0							
		Эрүүл мэндийг дэмжих байгууллага шалгаруулах хөдөлгөөн өрнүүлж, жил бүр шалгаруулах тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх			10,0							
		Сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг өргөжүүлэх, эрүүл ахуйн шаардлагад тогтмол хяналт тавих										
4.7	Хувь хүний зан үйлтэй холбоотой өвчлөл, буруу зуршлын шалтгааныг судалж тогтоох, сайжруулах арга замыг тодорхойлох, хэрэгжүүлэх	Боловсролын бүх шатны байгууллагын орчноос шалтгаалсан өвчлөл, суралцагчдын бие бялдрын хөгжлийн төвшинг тодорхойлох судалгаа хийх	ЭМЯ	БСШУЯ, ЗГХА-БТСГ, ММССан	30,0							
		Эрүүл зан үйлийг дэмжсэн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэх орчин нөхцөл бүрдүүлж хэвшил болгосон сургалтын байгууллагыг шалгаруулан туршлагыг нэвтрүүлэх	ЭМЯ	БСШУЯ, ЗГХА-БТСГ, ММССан	11,0							

Зорилт 5: Эрүүл мэндийн боловсролыг дэмжих ухуулга нөлөөллийн үйл ажиллагаа, зан үйлийг өөрчлөх МСС-ны төрөл, чанарыг сайжруулж, насанд туршдаа эрүүл мэндийн боловсрол эзэмших нөхцөл боломжийг нэмэгдүүлэх

Гарах үр дүн: Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл аж төрөх зан үйл, хандлагыг өөрчлөх ухуулга, нөлөөллийн ажлын нэр төрөл, хүртээмжийг дээшлүүлнэ.

Шалгуур үзүүлэлт:

- Хүүхэд, өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулсан ухуулга, сурталчилгаа, нөлөөллийн ажлын тооны өсөлт

5.1	Одоо ашиглагдаж буй сургалтын материалуудад үнэлгээ өгөх замаар эрүүл мэндийн хичээлд хэрэглэх нэмэлт материалын хэрэгцээг тодорхойлох	МСС-ны материалын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүргэх мэдээллийн тоо, давтамжийг үе шаттай нэмэгдүүлэх	БСШУЯ	ЭМЯ, ММССан, ЗГХА-ЭМГ	7						
5.2	Нийт хүн ам, ялангуяа хүүхэд, өсвөр насныханд зориулсан эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэхэд мэдээлэл, харилцааны технологийн дэвшлийг ашиглах	Эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх үйлчилгээнд веб сайт болон нээх, DVD, хүүхэлдэйн кино бүтээх	БСШУЯ	ММССан, ЗГХА-ЭМГ	10						
5.3	Хүүхэд, залуучуудад эрүүл мэндээ хамгаалах эрсдэлгүй зан үйл төлөвшүүлэх чиглэлээр ухуулга, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өргөжүүлэх	Хүүхэд, өсвөр үеийнхний дунд “Дэвжээ” болон “АХА” бусад уралдаан цэнгээнт нэвтрүүлэг зохион байгуулах замаар тэдний эрүүл мэндээ хамгаалах мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх	БСШУЯ	ЭМЯ, ММССан, ЗГХА-ЭМГ Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл	20,0						

5.4	Хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн цогц мэдээлэл хүргэдэг арга, хэрэгсэл ашиглан тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх	“Мэдлэгийн өртөө” аяныг ерөнхий боловсролын сургууль бүрт өрнүүлэх замаар хүүхэд бүрийг эрүүл мэндийн цогц мэдлэгтэй болоход нь туслах	БСШУЯ	ЗГХА-ЭМГ, Аймаг, нийслэлийн БСГ	19,0							
5.5	Иргэд олон нийтэд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх сургалтын аудио, видео материалууд боловсруулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан олон нийтэд хүргэх	Баг, хороо зэрэг алслагдсан газар явуулын сургалтад ашиглах зориулалттай, авч явахад хялбар, хэрэгцээт агуулга бүхий сургалтын багц материал боловсруулах, түгээх	ЭМЯ	БСШУЯ ММССан, ЗГХА-ЭМГ	10,0							

Зорилт 6: Эрүүл мэндийн боловсролын төвшин тогтоох, өсвөр үе, залуучуудын зан үйлийн төлөвшлийг үнэлэх аргазүйг боловсруулан, хяналт шинжилгээг тогтмолжуулах, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх

Гарах үр дүн: Хүүхэд өсвөр үеийнхний эрүүл зан үйлийн чадвар дадлыг үнэлэх цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээ тодорхойлж бодлогын шийдвэрт өөрчлөлт оруулна.

- Шалгуур үзүүлэлт:**
- Эрүүл зан үйл төлөвшсөн хүүхэд, өсвөр үеийнхний тоо
 - Эрүүл мэндийн боловсролын чиглэлээр хийсэн эрдэм шинжилгээ судалгааны ажлын тоо

6.1	Эрүүл мэндийн боловсролын талаар мэдээлэл авч боловсролын статистик мэдээллийн тогтолцоонд оруулдаг болох	ЕБС-иас эрүүл мэндийн боловсролын статистик мэдээлэл авах маягтыг боловсруулах, санал авах	БСШУЯ	Боловсролын Хүрээлэн, ЗГХА-ЭМГ	5,0							
		Статистик мэдээлэл авах маягтыг турших, сайжруулах	БСШУЯ	Боловсролын Хүрээлэн	10,0							

		Боловсролын статистик мэдээлэлд эрүүл мэндийн боловсролын талаар мэдээлэл тогтмол авч дүгнэлт хийх	БСШУЯ	Боловсролын Хүрээлэн								
		АББ-ын Гэгээрэл төвөөс зохион байгуулсан эрүүл мэндийн сургалтын талаар мэдээлэл авч, сургалтад хамрагдсан хүний тоог гаргах	БСШУЯ	АББЗСҮТ								
6.2	Хүүхэд, өсвөр үе, залуучуудын нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн эрүүл мэндийн зан үйлийн чадвар, дадлыг үнэлэх арга зүйг боловсруулан турших, хэрэгжүүлэх	Зан үйлийн судалгаа авах олон улсын аргачлалыг нэвтрүүлэх	ЭМЯ	Боловсролын Хүрээлэн, НЭМХ	5,0							
		ЕБС, МСҮТ болон их дээд сургууль, мөн цэцэрлэгт хамрагдагсад, сургууль завсардсан хүүхэд залуусын зан үйлийн төлөвшлийн тандалт, судалгааг 2 жил тутам хийх	БСШУЯ	ЭМЯ, ЗГХА-ЭМГ, ММССан,	90,0							